

SikaSwell® S-2

Хөөдөг чигжээс

Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaSwell® S-2 нь устай хүрэлцэхэд хөөж тэгдэг, дан бүрэлдэхүүнт полиуретан чигжээс юм.

Хэрэглээ:

SikaSwell S-2 –г бүтээцийн заагийг уснаас битүүлэх болон SikaSwell® – P Профиль, Sika Injectoflex® хоолойг тогтооход ашиглана.

Зай завсрыг битүүлэх зорилгоор:

- Барилгын бүх төрлийн зай залгаасууд
- Хана болон шалаар нэвтэрсэн сантехникийн хоолой болон ган төмөр эдлэлүүд
- Кабель болон бусад хоолойнуудад г.м ашиглана

Эдлэл тогтоох зорилгоор:

- Sika Injectoflex® системийн HP болон NS төрлийн хэрэглээнд
 - SikaSwell® – P Профилуудыг тогтооход ашиглана.
-

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Хэрэглээ хялбар
 - Олон төрлийн гадаргуутай наалдан барьцалдах чадвартай
 - Тэлэлтийн түвшин маш оновчтой зөв, тиймээс шинэ цутгасан бетонд бэхжилтийн явцад гэмтэл учруулахгүй.
 - Эдийн засгийн хувьд өндөр өгөөжтэй
 - Устай хүрэлцсэнээр хөөдөг
 - Усыг тэсвэрлэх тогтмол чанартай
 - Олон төрлийн деталь хэсэг бүхий талбайд хэрэглэхэд тохиромжтой
-

Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас

Хэлбэр / Төлөв

Өнгө

Улаан хүрэн

Construction

Sika®

Сав баглаа боодол 600 мл / 1 хайрцаганд - 20 ш-тэй
300 мл / 1 хайрцаганд 12 ш-тэй

Хадгалалт

Хадгалах нөхцөл / хугацаа Сав баглаа боодол онгойж, цоороогүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 9 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд +5°C+25°C орчинд хадгална.

Техникийн мэдээлэл

Химийн найрлага Агаарын чийгшилд бэхжих 1-бүрэлдэхүүнт полиуретан

Нягт ~ 1.33 кг/л (+23°C орчинд)

Бүрхүүл үүсэх хугацаа ~ 2 цаг (+23°C орчинд)

Бэхжилтийн зэрэг ~ 2,0 мм / 24 цагт (+23°C орчинд)
~ 10,0 мм / 10 хоногт (+23°C орчинд)

Гулзайлт – Урсалт < 2 мм

Эзлэхүүний өөрчлөлт Крантны усанд 1 хоног байлгах < 25%
Крантны усанд 7 хоног байлгах > 100%
Хавдаж хөөх чадвар нь давстай усанд буурч, удааширна

Системийн мэдээлэл

Хэрэглээний мэдээлэл

Гадаргуун чанар Гадаргуу тоос шороо, тос тосоол зэрэг урвалд орж болзошгүй элдэв бохирдолгүй цэвэрхэн, бат бэх нэгэн жигд гадаргуу байх шаардлагатай.

Гадаргууг бэлдэх Гадаргууг бэлдэхэд ашиглагдах гар болон автомат багаж ашиглан гадаргуу дээрх сул хэсгүүд болон бүх төрлийн бохирдлууд, барьцалтанд сөргөөр нөлөөлөх гадаргуун арчилгааны бодис, будагнуудыг цэвэрлэсэн байна

Гүйцэтгэлийн нөхцөл / Хязгаарлалтууд

Гүйцэтгэлийн орчны температур +5°C-ээс +35°C-ийн орчинд

Гадаргуун температур +5°C-ээс +35°C

Гадаргуун чийгшлийн Хэмжээ Гадаргуу хуурай,

Хэрэглэх заавар

Хэрэглэх аргачлал /

Багаж SikaSwell –P Профиль болон Sika Injectoflex хоолойг тогтоох зориулалтаар хэрэглэх тохиолдолд:

Бэлдсэн гадаргуу дээр SikaSwell S-2 –ийг ойролцоогоор 5 мм-ийн өргөнтэй гурвалжин хошуугаар түрхэнэ. Тэгш бус деталь хэсэг ихтэй

гадаргуу дээр SikaSwell S-2-ийг хийцийн дагуу тохируулан түрхэж өгнө. Үүний дараа SikaSwell S-2 дээр SikaSwell P Профиль болон Sika Injectoflex хоолойг сайтар дарж барьцалдуулан тавьна. Ойролцоогоор 2-3 цаг SikaSwell S-2-ийг бэхжүүлсэний дараа шингэн бетоны цутгалтыг дээрээс нь хийнэ. Дээр дурьдагдсан бүтээгдэхүүний техникийн танилцуулгыг сайтар уншиж, танилцсан байх хэрэгтэй.

Барилгын залгыг бүлж чигжих чигжээс:

SikaSwell S-2-ийг доорх хүснэгтийн дагуу гурвалжин хошуугаар шахаж түрхэнэ.

Бүтээцийн зузаан	Гурвалжин хошууны хэмжээ	600 мл савлагаатай чигжээсний зарцуулалт	300 мл савлагаатай чигжээсний зарцуулалт
< 30 см	15 мм	6.2 м	3.1 м
30 - 50 см	20 мм	3.6 м	1.8 м

Зарцуулалтын хэмжээ бодит байдал дээр хүснэгтэнд зааснаас зөрүүтэй гарах магадлалтай (гадаргуун тэгш бус гадаргуу, дүүргэгч материалын хэмжээ г.м.)байдаг.

SikaSwell S-2 ийг бетоны төв хэсэгт голлуулан түрх, Түрхлэг бүхий чигжээсний 2 талд 10 см (төмөр арматурчлалтай бетон), 15 см-ийн зузаантай (төмөр арматурчлалгүй бетон) бетоноор хучигдах ёстой. Цутгалтын өндрийн хувьд < 50 см тохиолдолд, чигжээс бүтээгдэхүүний түрхсэнээс хойш 2 – 3 цаг бэхжсэний дараа цутгаж болно. Хэрэв цутгалтын өндөр > 50 см тохиолдолд чигжээс бүтээгдэхүүнийг хамгийн багадаа 2 хоног бэхжүүлсэний дараа цутгалтаа хийх хэрэгтэй. Цутгалтын явцад SikaSwell S-2 чигжээсний эргэн тойронд сайтар нягтаршуулж, болзошгүй нүх сүв, сийрэг бетон үүсэхээс сэргийл.

Цэвэрлэгээ

Ажлын дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ Sika® Colma Cleaner цэвэрлэгч бодисуудаар цэвэрлэнэ. Хатсан болон бэхэжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар нь цэвэрлэх боломжтой.

**Анхаарах зүйлс /
Боломжууд**

SikaSwell S-2 нь устай хүрэлцэхэд хавдаж тэлдэг. Гэхдээ энэ өөрчлөлт нь богино хугацаанд огцом явагддаггүй, хэдэн цагийн дараа бага багаар хавдаж тэлнэ. Гэсэн хэдий ч SikaSwell S-2-ийг удаан хугацаагаар тогтмол усанд орхихгүй байхыг зөвлөж байна(усыг 24 цагийн дотор шахаж зайлуулах хэрэгтэй).

SikaSwell S-2-ийг хөдөлгөөнт заагт хэрэглэж болохгүй.

Усны түвшин богино хугацаанд огцом хурдтайгаар нэмэгдсэн тохиолдолд SikaSwell S-2 хөөж тэлсэний дараа усанд тэсвэртэй үйлчилгээгээ үзүүлнэ.

Хуурай орчинд SikaSwell S-2 нь өөрийн эхний төлөв хүртэл агшдаг бөгөөд устай дахин хүрэлцсэн тохиолдолд буцаад тэлж хөөдөг.

SikaSwell S-2 нь 5 баарын усны даралтыг тэсвэрлэх чадвартай хэдий ч чигжээсний хоорондын зайны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2 баараас илүү усны даралтгүй орчинд хэрэглэхийг зөвлөж байна. 2 баараас илүү өндөр усны даралттай орчинд SikaSwell S-2-ийг Sika Waterbar болон Sika Injectoflex хоолойг барьцалдуулан наах зориулалтаар хэрэглэж болно.

Дүгнэлт

Энэхүү Техникийн зааварчилгаанд дурьдагдсан үзүүлэлтүүд бүгд лабораторын туршилтанд үндэслэгдсэн болно. Бодит үзүүлэлтүүд нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарна уу.

Дотоодын хязгаарлалт

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл ялгаатай хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэст холбогдож зөвлөгөө авах боломжтой.

Аюулгүй ажиллагааны Заавар

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон физик, хими, байгаль орчны бусад нарийн мэдээллүүд бүтээгдэхүүний Эрүүл ахуй, Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.

Хэрэглэхдээ анхаарах зүйл Чигжээс бүтээгдэхүүн бүрэн хатаагүй орчинд бүтээгдэхүүнд ямарч хүнсний зүйл болон хүнсний сав суулгыг хүргэж болохгүй учир нь эмзэг мэдрэмтгий арьстай хүмүүст цочрол өгч болзошгүй. Тиймээс уг орчинд заавал хувийн хамгаалах хэрэгсэл буюу хувцас, бээлий, нүдний шил хэрэглэх нь зүйтэй. Мөн ажил дууссаны дараа биенд наалдсан чигжээс бүтээгдэхүүнийг халуун бүлээн ус, савантай усаар угаах, эсвэл резин цэвэрлэгч тос түрхэх нь зүйтэй. Уусгагч бүхий хүчтэй бодис хэрэглэхээс зайлхийх хэрэгтэй. Арьсаа хатаахын тулд даавуу бус харин нэг удаагийн цаасан алчуур хэрэглэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэж байгаа газар агааржуулалт сайтай байх ёстой. Нүд болон ам руу бүтээгдэхүүн орсон тохиолдолд цэвэр усаар сайтар зайлаад эмчид ханд.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өгөхөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika Services AG
Tueffenwies 16
CH-8048 Zurich
Switzerland

Phone: +41 44 436 40 40
Telefax: +41 44 436 46 86
www.sika.com

